

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР



СТАТИСТИКИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн эдийн засаг,
нийгмийн байдал

2017 он
1-р сар

АГУУЛГА


	Хуудасны дугаар
 НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	2
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	4
 АЖ ҮЙЛДВЭР	13
 МАЛ АЖ АХУЙ	16
 ДОТООД ХУДАЛДАА	16
 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	17
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	18
 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	19
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	21
 ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ	25
 ГЭМТ ХЭРЭГ	26
 ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	28

Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн 01 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Шинээр төрсөн хүүхэд	тоо	3171 ^{↑13.0}	3147 ^{↓0.8}	3382 ^{↑7.5}	3221 ^{↓4.8}	2823 ^{↓12.3}
Ажилгүйчүүд, сарын эцэст	мянган хүн	13.5 ^{↓54.1}	11.8 ^{↓12.6}	14.8 ^{↑25.4}	13.5 ^{↓8.8}	11.8 ^{↓12.2}
үүнээс : эмэгтэй	мянган хүн	6.9 ^{↓42.5}	6.3 ^{↓8.7}	8.0 ^{↑27.0}	7.2 ^{↓10.0}	6.0 ^{↓16.5}
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	1685 ^{↓2.1}	1254 ^{↓25.6}	1511 ^{↑20.5}	3528 ^{↑133.5}	1970 ^{↓44.2}
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	1446 ^{↑9.0}	1600 ^{↑10.7}	1937 ^{↑21.1}	1735 ^{↓10.4}	1739 ^{↑0.2}
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	1.5 ^{↓1.4}	1.7 ^{↑0.2}	0.5 ^{↓1.2}	0.4 ^{↓0.1}	0.9 ^{↑0.5}
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	1393 ^{↑1.9}	1723 ^{↑23.7}	1945 ^{↑12.9}	2011 ^{↑3.4}	2459 ^{↑22.3}

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийн хувь


^{↑, ↓} эерэг
^{↑, ↓} сөрөг
 = тогтвортой



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 1-р сарын хэрэглээний үнийн индекс 2016 оны мөн үетэй харьцуулахад 3.0 хувиар, өмнөх оны эцэстэй харьцуулахад 0.9 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний үнийн индекс, 2015-2017 он



Хэрэглээний үнийн индекс 2017 оны 1-р сард өмнөх оны эцэстэй харьцуулахад 0.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 3.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 0.2 хувь, бусад бараа, үйлчилгээ 1.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 3. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр


Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2015-01</u> 2014-01	<u>2016-01</u> 2015-01	<u>2017-01</u> 2016-01	<u>2017-01</u> 2016-12
Ерөнхий индекс	109.3	101.0	103.0	100.9
Хүнсний бараа, ундаа, ус	103.9	94.6	105.2	103.4
Согтууруулах ундаа, тамхи	110.0	100.4	100.9	100.0
Хувцас, бөс бараа, гутал	109.0	102.1	102.5	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	122.2	101.6	105.6	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	108.5	105.4	101.9	100.1
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	111.4	106.0	102.7	100.2
Тээвэр	108.1	97.5	101.2	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.6	99.2	98.0	99.2
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	109.8	100.5	98.0	99.9
Боловсролын үйлчилгээ	117.7	123.6	101.9	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	105.1	103.5	101.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	107.6	105.1	103.9	101.0

2017 оны 1-р сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 27.0 хувийнх нь үнэ өсч, 13.0 хувийнх нь үнэ буурч, 60.0 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байлаа.

Хүснэгт 4. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	3.4	Энэ бүлгийн өсөлтөд махан бүтээгдэхүүн 6.9 хувиар, загас, далайн бүтээгдэхүүн 6.1 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг 4.3 хувиар, жимс, жимсгэнэ 1.1 хувиар, хүнсний ногоо 4.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.1	Энэ бүлгийн өсөлтөд гар ахуйн бараа 0.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.2	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь эм, тариа 0.2 хувиар, амбулаторийн үйлчилгээ 5.3 хувиар өссөнтэй холбоотой байв.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	-0.8	Энэ бүлгийн бууралт нь телефон аппарат, факсын хэрэгсэл 11.7 хувиар буурснаас шалтгаалжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	-0.1	Энэ бүлгийн бууралтад бичгийн болон зургийн хэрэгсэл 0.8 хувиар буурсан нь нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	1.0	Бусад бараа, үйлчилгээний өсөлт нь гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлс 1.6 хувиар, үнэт эдлэл, төрөл бүрийн цаг 0.4 хувиар тус тус өссөнтэй холбоотой байна.

Зураг 2. Нэг кг будааны дундаж үнэ, 2012-2017 оны 1-р сард, төгрөг




Зураг 3. Нэг кг дээд гурилын дундаж үнэ, 2012-2017 оны 1-р сард, төгрөг



2017 оны 1-р сард хүнсний зах, дэлгүүрт жижиглэн худалдаалах махны үнэ өмнөх сартай харьцуулахад хонины ястай мах 28.7 хувиар, үхрийн ястай мах 21.4 хувиар тус тус өссөн байна. Өмнөх сартай харьцуулахад талх, гурил, будааны бүлгийн үнэ 0.8 хувиар буурч, харин хүнсний ногооны бүлгийн үнэ 4.4 хувиар нэмэгджээ.

Зураг 4. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, 2012-2017 оны 1-р сард




Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, 2012-2017 оны 1-р сард



Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ

Багануур дүүргийн түүхий эдийн захын дундаж үнээр нас гүйцсэн адуу 425.0 мянган төгрөг, үхэр 750.0 мянган төгрөг, эр хонь 115.0 мянган төгрөг, эм хонь 110.0 мянган төгрөг, ямаа 70.0-75.0 мянган төгрөгийн ханштай байв.



Зураг 6. Нэг ширхэг өндөгний дундаж үнэ, 2012-2017 оны 1-р сард



2017 оны 1-р сарын 30-ны өдрийн үнийн ажиглалтаар “Хүчит шонхор” зах дээр нэг кг тэмээний мах 3300 төгрөг, “Далай ээж” зах дээр гахайн мах 6700 төгрөг, тахианы мах 5500 төгрөг, өндөг 275 төгрөгийн ханштай байв.

Хүснэгт 5. Нэг кг махны жижиглэн худалдах дундаж үнэ, 2013-2017 оны сараар, төгрөгөөр

Үхрийн мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013 он	7335	8025	7895	8330	8380	8275	8225	7710	7825	7245	7115	7280
2014 он	7980	7775	8425	8370	8685	8730	7955	7590	7635	7550	7495	7465
2015 он	7415	7565	7810	8080	8145	8445	7985	7230	7005	5975	5620	5520
2016 он	6165	6875	7105	8170	8495	7930	6950	6865	6120	5235	5495	5580
2017 он	6775											
Хонины мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013 он	6480	7095	7060	7420	7490	7470	7415	6710	6540	6215	6085	6245
2014 он	6855	6675	7040	7630	7800	7685	7030	6585	6395	5965	5835	5940
2015 он	5860	6140	6735	7460	7555	7455	6830	6050	5540	4510	4200	3930
2016 он	4625	5495	5970	6935	6945	6525	5780	5605	4940	4250	3945	4390
2017 он	5650											


Зураг 7. Нэг кг хонины махны дундаж үнэ
2017 оны 1-р сардЗураг 8. Нэг кг үхрийн махны дундаж үнэ
2017 оны 1-р сард

Хүснэгт 6. Арьс ширний дундаж үнэ, төгрөгөөр


	2014 он		2015 он		2016 он		2017 он
	I сар	XII сар	I сар	XII сар	I сар	XII сар	I сар
Тэмээний шир	27000	21000	22000	25000	23500	17500	24000
Адууны шир	35000	39000	45000	53333	30000	29333	41667
Үхрийн шир	52000	62000	60000	42833	46000	30667	42333
Хонины арьс	8500	4600	4300	1167	1000	2300	2000
Ямааны арьс /ноолууртай/	28000	20000	23000	12667	12000	23500	31333
Ямааны ноолуур	67000	68000	65000	40000	40000	48000	55000

Улаанбаатар хотын түүхий эдийн захуудын сарын дундаж үнээр тэмээний шир 24000 төгрөг, адууны шир 41667 төгрөг, үхрийн шир 1.8-2.3 метр урттай бол 32667 төгрөг, 2.3 метрээс дээш урттай нь 42333 төгрөг, хонины нэхий 2000 төгрөг, ямааны ноолууртай арьс 31333 төгрөг, ямааны ноолуур 55000 төгрөгийн ханштай байлаа.

Зураг 9. Ямааны ноолуурын дундаж үнэ, төгрөгөөр, 1-р сард



Зураг 10. Шатахууны үнэ, өөрчлөлт орсон өдрөөр




Хүснэгт 7. Түлшний үнэ, төгрөг

Байршил	2015.01.28			2016.01.27			2017.01.25		
	Түлшний мод шуудай (6-7 кг)		Нүүрс (Налайх) (12-14 кг)	Түлшний мод шуудай (6-7 кг)		Нүүрс (Налайх) (12-14 кг)	Түлшний мод шуудай (6-7 кг)		Нүүрс (Налайх) (12-14 кг)
	Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод	
Чингэлтэй	1200		2100	1800		2000	1800		2000
Сүхбаатар	1200		2200	1500		2200	1700		2100
Цайз зах	1000		2000	1500		2000	1700		1900
Хангай зах	900	800	2000	1500		2000	1800		1800
Дундаж үнэ	1075	800	2075	1575		2050	1750		1950

Хүснэгт 8. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2016.01.27					2017.01.25				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1750		1580	1690		1730		1530	1640	
Петровис	1750	1470	1580	1690		1730	1450	1530	1640	
Магнай трейд	1750	1470	1580	1690		1730	1450	1530	1640	
Сод монгол	1750		1580	1690		1730		1550	1640	
Шунхлай		1470	1580	1690			1450	1530	1640	
Юнигаз					1100					900
Дундаж үнэ	1750	1470	1580	1690	1100	1730	1450	1534	1640	900

Зураг 11. Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш, 2014-2017 он



Мэдээлийн эх сурвалж: Монголбанкны статистикийн мэдээлэл

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны 01-р сарын танилцуулга

Хүснэгт 9. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2016 оны 11, 12-р сар, 2017 оны 1-р сарын өдрүүдээр

		хэмжих нэгж	2016 11.09	2016 11.16	2016 11.23	2016 11.30	2016 12.07	2016 12.14	2016 12.21	2016 12.28	2017 01.04	2017 01.11	2017 01.18	2017 01.25	17.01.25 17.01.18
"Алтан тариа" гурил	дээд	кг	1270	1270	1270	1270	1265	1265	1260	1260	1260	1260	1260	1260	100.0
	1-р зэрэг	кг	1065	1065	1065	1065	1040	1040	1035	1035	1035	1035	1035	1025	99.0
"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг	1585	1585	1585	1585	1585	1585	1585	1585	1585	1585	1585	1585	100.0
	дээд	кг	1305	1305	1305	1305	1300	1300	1300	1300	1300	1300	1300	1300	100.0
	1-р зэрэг	кг	1095	1095	1095	1095	1085	1085	1085	1085	1085	1085	1085	1085	100.0
	2-р зэрэг	кг	825	825	825	825	825	825	825	825	825	825	825	830	100.6
"Алейка" дээд гурил		кг	1305	1305	1305	1305	1305	1305	1305	1305	1305	1305	1305	1305	100.0
Сүү	Сүү ХК 1л	литр	2135	2145	2155	2165	2190	2225	2240	2240	2250	2250	2245	2250	100.2
	Сүү ХК 0.5л	литр	935	935	935	935	945	960	960	960	965	965	970	1035	106.7
	Задгай	литр	1250	1250	1250	1250	1250	1250	1250	1250	1250	1250	1250	1275	102.0
Тараг, Цөцгийтэй		литр	2060	2060	2075	2085	2085	2085	2095	2085	2085	2095	2100	2160	102.9
Талх	Атар	ширхэг	1160	1160	1160	1160	1165	1165	1165	1165	1165	1165	1165	1165	100.0
	Зууван чех	ширхэг	1215	1215	1215	1215	1215	1215	1215	1215	1215	1215	1215	1215	100.0
	Хар талх	300 гр											850	865	101.8
Будаа	цагаан	кг	2575	2575	2575	2605	2605	2605	2605	2605	2615	2615	2615	2615	100.0
	шар	кг	1730	1730	1730	1730	1730	1730	1730	1730	1730	1730	1730	1730	100.0
Цөцгийн тос, "Сүү" ХК		кг	3255	3255	3255	3255	3255	3255	3255	3255	3255	3255	3255	3255	100.0
Ургамлын тос, "Янта"		1 литр												3380	
Ногоон цай, Гүрж		90 гр												1485	
Элсэн чихэр		кг	2315	2315	2315	2315	2315	2315	2315	2315	2315	2315	2315	2315	100.0
Хонины мах	ястай	кг	3885	3940	4095	3860	4110	4260	4260	4935	5510	5705	5705	5675	99.5
	цул	кг	4945	4945	5055	5045	5045	5145	5145	5655	5955	6215	6170	6170	100.0
Үхрийн мах	ястай	кг	5370	5480	5660	5575	5270	5685	5625	5735	6625	6765	6810	6900	101.3
	цул	кг	7115	7115	7105	7215	7255	7670	7670	7675	8070	8235	8260	8355	101.2
Адууны мах, ястай		кг	4405	4405	4405	4405	4405	4405	4405	4405	4650	4650	4650	4625	99.5
Ямааны мах, ястай		кг	3285	3285	3355	3355	3430	3650	3505	3590	4300	4300	4300	4300	100.0
Төмс, монгол		кг	725	725	735	735	730	740	750	750	745	740	740	740	100.0
Лууван, монгол		кг	915	915	915	915	1055	1010	995	1020	1020	1030	1030	1055	102.4
Байцаа, монгол		кг	800	800	800	800	950	1145	1255	1300	1300	1300	1300	1275	98.1
Хүрэн манжин, монгол		кг											1575	1500	95.2
Сонгино, хятад		кг	1255	1255	1255	1255	1255	1255	1255	1255	1255	1255	1255	1255	100.0
Алим, фүжи		кг	4170	4170	4170	4170	4170	4170	4170	4170	4170	4170	4170	4170	100.0
Өндөг, ОХУ		ширхэг	270	270	270	270	275	275	275	275	275	275	275	275	100.0

Хүснэгт 10. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2011-2017 оны 1-р сарын IV долоо хоногоор

		хэмжих нэгж	2011.01	2012.01	2013.01	2014.01	2015.01	2016.01	2017 01.25	2017 2016	2017 2015	2017 2014	2017 2013	2017 2012	2017 2011
"Алтан тариа" гурил	дээд	кг	881	845	904	1110	1185	1270	1260	99.2	106.3	113.5	139.4	149.1	143.0
	1-р зэрэг	кг	737	696	718	770	1005	1065	1025	96.2	102.0	133.1	142.8	147.3	139.1
"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг	1034	1092	1143	1585	1545	1595	1585	99.4	102.6	100.0	138.7	145.1	153.3
	дээд	кг	943	911	926	1155	1220	1295	1300	100.4	106.6	112.6	140.4	142.7	137.9
	1-р зэрэг	кг	773	757	788	795	1035	1090	1085	99.5	104.8	136.5	137.7	143.3	140.4
	2-р зэрэг	кг	597	597	594	595	830	835	830	99.4	100.0	139.5	139.7	139.0	139.0
"Алейка" дээд гурил		кг	933	905	1281	1320	1325	1310	1305	99.6	98.5	98.9	101.9	144.2	139.9
Сүү	Сүү ХК 1л	литр			1710	2045	2460	2090	2250	107.7	91.5	110.0	131.6		
	Сүү ХК 0.5л	литр			671	880	1215	905	1035	114.4	85.2	117.6	154.2		
	Задгай	литр	1225	1233	1180	1535	1400	1300	1275	98.1	91.1	83.1	108.1	103.4	104.1
Тараг, Цөцгийтэй		литр			1624	2075	2155	2185	2160	98.9	100.2	104.1	133.0		
Талх	Атар	ширхэг	632	650	658	835	1065	1150	1165	101.3	109.4	139.5	177.1	179.2	184.3
	Зууван чех	ширхэг			924	920	1180	1255	1215	96.8	103.0	132.1	131.5		
	Хар талх	300 гр							865						
Будаа	цагаан	кг	1700	1677	1725	2270	2350	2520	2615	103.8	111.3	115.2	151.6	155.9	153.8
	шар	кг	1627	1618	1635	1575	1795	1695	1730	102.1	96.4	109.8	105.8	106.9	106.3
Цөцгийн тос, "Сүү" ХК		кг			2238	2295	2975	3255	3255	100.0	109.4	141.8	145.4		
Ургамлын тос, "Янта"		1 литр							3380						
Ногоон цай, Гүрж		90 гр							1485						
Элсэн чихэр		кг	1694	1697	1729	1650	1730	1785	2315	129.7	133.8	140.3	133.9	136.4	136.7
Хонины мах	ястай	кг	4239	4994	7225	7445	6780	5500	5675	103.2	83.7	76.2	78.5	113.6	133.9
	цүл	кг	4450	5080	7120	7525	7030	5950	6170	103.7	87.8	82.0	86.7	121.5	138.7
Үхрийн мах	ястай	кг	4800	5625	7814	8420	8000	6720	6900	102.7	86.3	81.9	88.3	122.7	143.8
	цүл	кг	5438	6263	8857	9965	9620	8080	8355	103.4	86.9	83.8	94.3	133.4	153.6
Адууны мах, ястай		кг	3480	4417	5967	6700	5675	4825	4625	95.9	81.5	69.0	77.5	104.7	132.9
Ямааны мах, ястай		кг	3260	4180	5350	5700	4975	3800	4300	113.2	86.4	75.4	80.4	102.9	131.9
Төмс, монгол		кг	955	973	1050	900	1155	1065	740	69.5	64.1	82.2	70.5	76.1	77.5
Лууван, монгол		кг	952	944	1200	1295	1225	1625	1055	64.9	86.1	81.5	87.9	111.8	110.8
Байцаа, монгол		кг	1029	944	1450	1250	1145	1480	1275	86.1	111.4	102.0	87.9	135.1	123.9
Хүрэн манжин, монгол		кг							1500						
Сонгино, хятад		кг	979	984	1270	1285	1195	1255	1255	100.0	105.0	97.7	98.8	127.5	128.2
Алим, фүжи		кг			3829	3825	4245	3920	4170	106.4	98.2	109.0	108.9		
Өндөг, ОХУ		ширхэг	238	259	269	410	320	285	275	96.5	85.9	67.1	102.2	106.2	115.5

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны 01-р сарын танилцуулга

Хүснэгт 11. Хүнсний барааны үнийн зэрэгцүүлэлт, 2017 оны 1-р сарын 25-ны өдрийн байдлаар


		хэмжих нэгж	Баянзүрх зах	Сансар Супер-маркет	Хүчит шонхор зах	Бөмбөгөр ХТ	Меркури зах	Барс ХТ	Таван эрдэнэ зах	Хархорин зах	Номин Супер-маркет	Макс Супер-маркет	Оргил Супер-маркет	Е Март	Дундаж үнэ
"Алтан тариа" гурил	дээд	кг	1300	1299	1300	1150		1100	1300	1300	1299	1332	1243	1218	1260
	1-р зэрэг	кг	1100	1050	1100	900		950	1100	1100	910	1068		978	1025
"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг	1600	1610	1600	1500	1800	1500	1500	1550	1579	1660	1540	1580	1585
	дээд	кг	1300	1330	1300	1200	1500	1200	1300	1300	1289	1360	1290	1240	1300
	1-р зэрэг	кг	1100	1090	1100	1000	1300	1000	1100	1100	1049	1100	1088	1010	1085
	2-р зэрэг	кг	850	860	800	800		800	900	800			830	830	830
"Алейка" дээд гурил		кг	1300	1260	1200	1300	1500	1200	1300	1300	1379	1370	1270		1305
Сүү	Сүү ХК 1л	литр	2200	2360	2300	2200	2300	2200	2300	2200	2299	2220	2220	2220	2250
	Сүү ХК 0.5л	литр	1000	1060	1000	1000	1200	1000	1100	1000	1030	1000	1020	1000	1035
	Задгай	литр			1000				1200	1200	1699				1275
Тараг, Цөцгийтэй		литр	2100	2280	2100	2000	2300	2100	2300	2100	2249	2100	2160	2130	2160
Талх	Атар	ширхэг	1200	1210	1200	1100		1100	1200	1100	1209	1170	1100	1200	1165
	Зууван чех	ширхэг	1300	1270	1300	1150		1150	1250	1150	1169	1200	1200	1200	1215
	Хар талх	300 гр	850		900	800	1000	800		800	919	890	800	880	865
Будаа	цагаан	кг	2300	3260	2400	2200		2400	2300	2400	3249	2580	3060		2615
	шар	кг	1600	2100	1500	1500		1300	1900	1800		2140			1730
Цөцгийн тос, "Сүү" ХК		кг	3200	3300	3000	3500	3500	3000	3500	3200	3279	3220	3080		3255
Ургамлын тос, "Янта"		1 литр	3300	3570	3300	3300		3200		3300	3500	3550			3380
Ногоон цай, Гүрж		90 гр	1450	1550	1500	1400		1400		1500		1540	1520		1485
Элсэн чихэр		кг	2200	2500	2000	2200	2500	2100	2300	2000		3000	2370		2315
Хонины мах	ястай	кг	5100	4500	5000	5800	7500	6200	6800	5000		4950		5900	5675
	цул	кг	5700		5600	6500		6500	7500	5400		6000			6170
Үхрийн мах	ястай	кг	6500	5800	6800	8000	7500	7000	7000	6400	7499	5800		7600	6900
	цул	кг	8000	7000	8500	8800	9000	8500	8500	8000	8799	7800		8980	8355
Адууны мах, ястай		кг	4500		4500	5000				4500					4625
Ямааны мах, ястай		кг	4000		4300	4800				4100					4300
Төмс, монгол		кг	800	690	600	700	800	600	1000	600	649	640	1200	590	740
Лууван, монгол		кг	1000	800	1000	1000	1200	900	1000	1000	1399	1000	1500	880	1055
Байцаа, монгол		кг	800	1500	1000	1000	1000	1000	1200	1000	1500		2500	1550	1275
Хүрэн манжин, монгол		кг	1500	1500	1500	1500	1700	1300	1500	1500					1500
Сонгино, хятад		кг	1500	1050	1000	1300	1500	1000	1200	1100	1199	1450	1500		1255
Алим, фүжи		кг	3500		3500	4500	4000	3500	4500	4000	4899	4800	4500		4170
Өндөг, ОХУ		ширхэг	250	260	250	230	300	250	300	250	279	300	280	350	275



АЖ ҮЙЛДВЭР


Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2017 оны 1-р сард 580.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 621.8 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 26.4 хувиар, борлуулалт 24.1 хувиар өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэлт 2.9 хувиар буурч, уул уурхайн олборлох үйлдвэрлэлт 39.5 хувиар, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 17.7 хувиар, боловсруулах үйлдвэрлэлт 18.1 хувиар тус тус өссөн байна.

Зураг 12. Аж үйлдвэрийн 2016-2017 оны үйлдвэрлэлт, борлуулалт /тэрбум.төг/




Нийслэлийн аж үйлдвэрийн салбар 2017 оны 1-р сард 580.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхайн олборлох салбар 61.6 хувийг, цахилгаан дулааны эрчим хүч усан хангамжийн үйлдвэрлэлт 13.6 хувийг, боловсруулах үйлдвэрлэлт 24.8 хувийг тус тус эзэлж байна. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын өсөлтөнд хүнсний үйлдвэрлэлт, нэхмэлийн үйлдвэрлэлт, арьс шир боловсруулах үйлдвэрлэлт, мод модон эдлэл үйлдвэрлэлт, цаас цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, тээврийн бусад хэрэгсэлийн үйлдвэрлэлт, мебель тавилга үйлдвэрлэлт болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт голлон нөлөө үзүүлсэн байна.

Зураг 13. Махны үйлдвэрлэлт, мян.тн




Зураг 14. Гурил үйлдвэрлэлт, мян.тн



Зураг 15. Талх, архи дарсны үйлдвэрлэлт



Зураг 16. Нүүрс олборлолт, мян.тн




Хүснэгт 12. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/


Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2016 он I сар	2017 он I сар	$\frac{2017}{2016}$ %
Уул уурхай олборлох үйлдвэр	256344.3	357670.2	139.5
Нүүрс олборлолт	28823.4	74859.1	2.6*
Газрын тос, шатдаг хий олборлолт	51096.6	86026.6	168.4
Төмрийн хүдэр олборлолт	175258.2	189947.9	108.4
Бусад ашигт малтмал олборлолт	1166.1	6836.6	5.9*
Боловсруулах үйлдвэр	121771.5	143754.9	118.1
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	63890.1	75194.2	117.7
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	6680.4	5582.2	83.6
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4394.3	7728.8	175.9
Үр тарианы гурил, малын тэжээл	11005.9	14850.5	134.9
Хүнсний бусад бүтээгдэхүүн	9091.8	8977.1	98.7
Ундаа үйлдвэрлэл	32717.7	38055.6	116.3
Тамхи үйлдвэрлэл	0.0	2083.3	
Нэхмэлийн үйлдвэрлэлт	18589.4	20573.2	110.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	645.5	492.4	76.3
Арьс шир боловсруулах үйлдвэр	1537.8	1981.3	128.8
Мод модон эдлэл үйлдвэрлэл	715.9	931.8	130.2
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	722.9	977.8	135.3
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	2035.5	2358.2	115.9
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2267.8	4709.0	2.1*
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	1603.8	1798.3	112.1
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	1006.1	875.7	87.0
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	183.8	120.6	65.6
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	200.0	241.5	120.8
Мебель тавилга үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэл	28372.9	31417.6	110.7
Цахилгаан, дулаан, усан хангамж	80981.8	78672.7	97.1
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	77086.9	74814.5	97.1
Ус ариутгал, усан хангамж	3894.9	3858.2	99.1
ДҮН	459097.6	580097.8	126.4

*дахин

Зураг 17. Үйлдвэрлэлт, 2015-2017 он, тэрбум төг



Зураг 18. Борлуулалт, 2015-2017 он тэрбум төг



Хүснэгт 13. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2016 он I сар	2017 он I сар	$\frac{2017}{2016}$ %	Үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	328046.5	357707.3	109.0	83.9
Нүүрс олборлолт	22699.6	48233.7	2.1*	68.0
Газрын тос, шатдаг хий олборлолт	49262.8	76286.3	154.9	100.0
Төмрийн хүдэр олборлолт	253080.6	226898.1	89.7	82.3
Бусад ашигт малтмал олборлолт	3003.5	6289.2	2.1*	72.6
Боловсруулах үйлдвэр	91852.7	185429.1	2.0*	53.7
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	62025.1	68464.0	110.4	13.9
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	3338.0	5490.4	164.5	39.6
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4527.5	8283.2	183.0	
Үр тарианы гурил, малын тэжээл	11514.7	15898.7	138.1	
Хүнсний бусад бүтээгдэхүүн	9103.5	9402.7	103.3	
Ундаа үйлдвэрлэл	33541.4	29389.0	87.6	25.0
Тамхи үйлдвэрлэл	5200.0	5406.2	104.0	22.7
Нэхмэлийн үйлдвэрлэлт	12960.7	14350.2	110.7	34.5
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	370.7	428.2	115.5	
Арьс шир боловсруулах үйлдвэр	1721.5	1905.8	110.7	85.2
Мод модон эдлэл үйлдвэрлэл	575.5	984.3	171.0	9.1
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	720.4	971.0	134.8	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	2163.5	2592.5	119.8	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2373.6	4724.8	199.1	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	1533.8	1800.3	117.4	
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	1151.2	785.7	68.3	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	37.5	197.3	5.3*	
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	155.6	238.2	153.1	
Мебель тавилга үйлдвэрлэл, бусад үйлдвэрлэл	863.6	82580.6	95.6*	99.5
Цахилгаан, дулаан, усан хангамж	80981.8	78672.7	97.1	
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	77086.9	74814.5	97.1	
Ус ариутгал, усан хангамж	3894.9	3858.2	99.1	
ДҮН	500881.0	621809.1	124.1	64.3

*дахин

Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 222.0 тэрбум төгрөгийг дотоодод, 399.8 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна.

2017 оны 1 сард борлуулсан нийт бүтээгдэхүүний 64.3 хувийг экспортоор гаргасан байна. Нийт экспортын 8.2 хувийг нүүрс олборлолт, 19.1 хувийг газрын тос шатдаг хий олборлолт, 46.7 хувийг төмрийн хүдэр олборлолт, 1.1 хувийг бусад ашигт малтмал олборлолт, 1.2 хувийг нэхмэлийн үйлдвэрлэлт, 0.4 хувийг арьс шир боловсруулах үйлдвэрлэлт, 2.4 хувийг хүнсний үйлдвэрлэлт, 0.3 хувийг тамхи үйлдвэрлэлт, мод модон эдлэл болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 20.6 хувийг түс түс эзэлж байна.



МАЛ АЖ АХУЙ

2017 оны 1-р сард 760 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар өсчээ. Хорогдсон нийт малын 1.9 хувийг адуу, 15.0 хувийг үхэр, 43.0 хувийг хонь, 40.1 хувийг ямаа эзэлжээ. Том малын зүй бус хорогдлын 10.5 хувь буюу 80 толгой мал өвчнөөр, 17.5 хувь буюу 133 нь хээлтэгч малын хорогдол эзэлж байна.

Хүснэгт 14. Том малын зүй бус хорогдол, дүүргээр, 1-р сард

Дүүрэг	2015 он	2016 он	2017 он	үүнээс :			
				адуу	үхэр	хонь	ямаа
Багануур	69	139	277	12	54	117	94
Багахангай	10	8	-				
Баянзүрх	-	24	37	-	15	13	9
Налайх	-	148	146	-	2	111	33
Сонгинохайрхан	12	208	64	-	26	10	28
Сүхбаатар	-	8	14	-	14	-	-
Хан-Уул	36	45	222	2	3	76	141
Чингэлтэй	2	3	-				
Дүн	129	583	760	14	114	327	305




ДОТООД ХУДАЛДАА

Жилд дунджаар 50.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж байгууллага худалдааны салбарын 10.0 гаруй хувийг эзэлж байгаа хэдий ч салбарын нийт борлуулалтын орлогын 90.0 гаруй хувь нь эдгээр нэгжид ногдож байна.

Улаанбаатар хотод бөөний болон жижиглэн худалдааны борлуулалт 2016 оны байдлаар 8663.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 1.6 хувиар өссөн байна.

Зураг 19. Дотоод худалдааны борлуулалт, 2014-2016 онд, /тэрбум.төг/



Нийслэл хотод 2016 оны байдлаар 8663.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн бол үүний 4287.5 тэрбум буюу 49.0 хувийг бөөний худалдаа, 4375.7 тэрбум буюу 51.0 хувийг жижиглэн худалдаа тус тус эзэлж байна.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны 1-р сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 4.9 мянган байгууллагын 82.0 мянган иргэд хамрагдаж, нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 42.0 мянга буюу 51.2 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 25.5 мянга буюу 31.1 хувь нь төсөвт байгууллагын, 14.5 мянга буюу 17.7 хувь нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар буюу 4.1 мянган хүнээр буурчээ.


Зураг 20. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагууд 2017 оны 1-р сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 119.2 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 62.8 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.9 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 18.8 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.2 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.5 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 1.6 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 21. Даатгалын сангийн зарлага



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас энэ оны 1-р сард даатгуулагч, иргэдэд 66.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ. Нийт зардлын 78.1 хувийг тэтгэврийн, 8.7 хувийг эрүүл мэндийн, 4.1 хувийг ҮОМШӨ-ний, 5.6 хувийг тэтгэмжийн, 3.5 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 1-р сард 153.5 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ 50.2 тэрбум төгрөгт хүрчээ.

Олгосон нийт тэтгэврийн 76.7 хувийг өндөр насны, 9.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.1 хувийг


тэжээгчээ алдсаны, 11.0 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2017 оны 1-р сарын эцэст 11830 болж, өмнөх оны мөн үеэс 12.2 хувь буюу 1649 хүнээр буурчээ. Нийт ажилгүйчүүдийн 5974 буюу 50.5 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 22. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 11.9 хувь буюу 1409 нь 15-24 насны, 40.7 хувь буюу 4808 нь 25-34 насны, 26.1 хувь буюу 3090 нь 35-44 насны, 21.3 хувь буюу 2523 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 19.0 хувь буюу 2245 нь Баянзүрх, 18.2 хувь буюу 2147 нь Сонгинохайрхан, 14.6 хувь буюу 1731 нь Чингэлтэй, 14.5 хувь буюу 1713 нь Баянгол, 12.4 хувь нь буюу 1472 нь Хан-Уул, 11.7 хувь буюу 1383 нь Сүхбаатар, 5.3 хувь буюу 629 нь Багануур, 3.1 хувь буюу 370 нь Багануур, 1.2 хувь буюу 140 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

2017 оны 1-р сард ажилгүй 2772 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 297 иргэн ажилд зуучлагдан орж, 2633 иргэн бүртгэлээс хасагджээ.

Хүснэгт 15. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /2-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2015 он	2016 он	2017 он	2015 он	2016 он	2017 он
Нийт ажилгүйчүүд	14845	13479	11830	100	100	100
Үүнээс: дээд боловсролтой	6116	4947	5222	41.2	36.7	44.1
Тусгай дунд боловсролтой	1053	889	679	7.1	6.6	5.7
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	816	666	567	5.5	4.9	4.8
Ерөнхий боловсролтой	6791	6899	5320	45.7	51.2	45.0
Мэргэжилгүй	69	78	42	0.5	0.6	0.4

2017 оны 1-р сард 2772 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 33.8 хувь буюу 1414 хүнээр буурчээ.

2017 оны 1-р сард 297 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 0.3 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 19.5 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 80.2 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны 1-р сард 2823 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 398 хүүхдээр цөөн байна.


Нийт төрсөн хүүхдийн 15.6 хувь буюу 440 нь бусад аймгийн харъяат эхчүүдээс төрсөн байна.

Хүснэгт 16. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, эхний 1 сард

	2015 он	2016 он	2017 он	$\frac{2017}{2016}$ %
Амаржсан эхийн тоо	3340	3198	2796	87.4
Амьд төрсөн хүүхэд	3382	3221	2823	87.6
Эхийн эндэгдэл	1	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	52	42	57	135.7
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	15.4	13.0	20.2	155.4

Нялхсын эндэгдлийн 35.6 хувь буюу 16 нь Баянзүрх, 22.2 хувь буюу 10 нь Хан-Уул, 13.3 хувь буюу 6 нь Сонгинохайрхан, 8.9 хувь буюу 4 нь Баянгол, 6.7 хувь буюу 3 нь Чингэлтэй, 6.7 хувь буюу 3 нь Сүхбаатар, 4.4 хувь буюу 2 нь Налайх, 2.2 хувь буюу 1 нь Багануур дүүрэгт тус тус гарсан байна. Нялхсын эндэгдлийн 21.1 хувь буюу 12 нь бусад аймгийн харъяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 7.2 промилээр өсчээ.

Зураг 23. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар




Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 31.7 хувийг салхин цэцэг, 15.4 хувийг тэмбүү, 12.9 хувийг трихомониаз, 10.2 хувийг заг хүйтэн, 9.6 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 5.8 хувийг цусан суулга, 4.6 хувийг улаан эсэргэнэ, 2.7 хувийг гар хөл амны өвчин, 1.1 хувийг вирус хепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Нийслэлд 2017 оны 1-р сард 1970 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 44.2 хувиар буюу 1558 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 12.2 продицимилээр буурчээ.

Хүснэгт 17. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 1 сард

	хэмжих нэгж	2016 он	2017 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	3528	1970	- 1558	- 1.8 дах
	10000 хүнд	26.8	14.6	- 12.2	
Вируст гепатит	бодит тоо	41	21	- 20	- 2.0 дах
	10000 хүнд	0.3	0.2	- 0.1	
Цусан суулга	бодит тоо	106	114	8	7.5
	10000 хүнд	0.8	0.8	0.0	
Салхин цэцэг	бодит тоо	459	625	166	1.4 дах
	10000 хүнд	3.5	4.6	1.1	
Гахай хавдар	бодит тоо	34	16	- 18	- 2.1 дах
	10000 хүнд	0.3	0.1	- 0.2	
Сальмонеллөз	бодит тоо	3	11	8	3.6 дах
	10000 хүнд	0.0	0.1	0.1	
Улаан эсэргэнэ	бодит тоо	103	90	- 13	- 12.6
	10000 хүнд	0.8	0.7	- 0.1	
Улаан бурхан	бодит тоо	1743	-	- 1743	-
	10000 хүнд	13.3	-	- 13.3	
Хоолны хордлого	бодит тоо	2	8	6	4 дах
	10000 хүнд	0.0	0.1	0.1	
Ёлом	бодит тоо	17	12	- 5	- 29.4
	10000 хүнд	0.1	0.1	0.0	
Бруцеллөз	бодит тоо	0	4	4	-
	10000 хүнд	0.0	0.0	0.0	
Гар хөл амны өвчин	бодит тоо	129	54	- 75	- 2.4 дах
	10000 хүнд	1.0	0.4	- 0.6	
Тэмбүү	бодит тоо	291	304	13	4.5
	10000 хүнд	2.2	2.3	0.1	
Заг хүйтэн	бодит тоо	202	200	- 2	- 1.0
	10000 хүнд	1.5	1.5	0.0	
Трихомониаз	бодит тоо	207	255	48	1.2 дах
	10000 хүнд	1.6	1.9	0.3	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	150	189	39	1.3 дах
	10000 хүнд	1.1	1.4	0.3	
ДОХ	бодит тоо	2	2	0	-
	10000 хүнд	0.0	0.0	0.0	



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж температур 2017 оны 1-р сард дунджаар -20.0°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс -3.9°C -аар хүйтэн, олон жилийн дундажтай харьцуулбал 1.5°C -аар дулаан байв.

Энэ сард үнэмлэхүй их температур -4.8°C , үнэмлэхүй бага температур -31.4°C , хур тунадасны нийлбэр 0.8 мм, салхины үнэмлэхүй их хурд 16 м/секунд хүрч, цасан бүрхүүлийн үнэмлэхүй зузаан 11 см байлаа.


Хүснэгт 18. Агаарын бохирдолт, $\text{мг}/\text{м}^3$, 1-р сард

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO_2	0.020	311	0.270	179	0.076
Азотын давхар исэл	NO_2	0.040	303	0.171	186	0.066
Тоосжилт	PM_{10}	0.100	335	0.738	276	0.221
	$\text{PM}_{2.5}$	0.050	181	0.539	174	0.198
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	621	14.058	8	2.955
Озон	O_3	0.100	603	0.610	86	0.017


* - Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2017 оны 1-р сард Улаанбаатар хотын Баруун 4 зам орчимд 31 удаа, Телевиз орчимд 28 удаа, Хархорин захын орчимд 23 удаа, 32-ын тойрог болон Амгалан орчимд тус бүр 20 удаа, Толгойт орчимд 18 удаа, 13-р хороолол орчимд 16 удаа, Ургах наран хороолол орчимд 15 удаа, Офицеруудын ордон орчимд 9 удаа, 1-р хороолол орчимд 6 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Толгойт болон Телевиз орчимд тус бүр 30 удаа, Амгалан орчимд 29 удаа, 13-р хороолол орчимд 27 удаа, 32-ын тойрог орчимд 20 удаа, 1-р хороолол орчимд 12 удаа, Баруун 4 зам орчимд 10 удаа, Офицеруудын ордон орчимд 9 удаа, Ургах наран хороолол орчимд 7 удаа, Хархорин зах орчимд 5 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.


Зураг 24. Хүхэрлэг хийн агууламж, $\text{мг}/\text{м}^3$



Зураг 25. Азотын давхар ислийн агууламж, мг/м^3




Зураг 26. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м^3



10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Телевиз орчимд 30 удаа, Нисэх болон Толгойт орчимд тус бүр 29 удаа, 1-р хороолол орчимд 28 удаа, Баруун 4 зам болон Хархорин зах орчимд тус бүр 27 удаа, 13-р хороолол болон 32-ын тойрог орчимд тус бүр 26 удаа, Амгалан орчимд 24 удаа, Мишээл экспо төвийн орчимд 17 удаа, Ургах наран хороолол орчимд 13 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Телевиз орчимд 31 удаа, Баруун 4 зам болон Нисэх орчимд тус бүр 30 удаа, Толгойт болон Амгалан орчимд тус бүр 29 удаа, 13-р хороолол орчимд 25 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 27. Тоосны PM_{10} агууламж, мг/м^3



Хүснэгт 19. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 1-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	-	0.047	0.054	0.087	0.102	0.045	0.038	0.052	0.029	0.124	0.164	0.093
	Хамгийн их	-	0.091	0.120	0.149	0.167	0.121	0.076	0.106	0.042	0.186	0.270	0.185
	XXX*-с давсан хувь	-	32.0	40.0	87.0	91.0	29.0	16.0	50.0	-	97.0	97.0	94.0
	Хэмжилтийн тоо	-	31	30	31	22	31	31	14	28	31	31	31
Азотын давхар Исэл NO ₂	Дундаж	-	0.110	0.042	0.127	0.068	0.045	0.060	0.051	0.035	0.064	0.064	0.056
	Хамгийн их	-	0.165	0.057	0.171	0.095	0.064	0.114	0.108	0.050	0.126	0.103	0.081
	XXX*-с давсан хувь	-	100.0	24.0	100.0	87.0	33.0	74.0	48.0	-	67.0	90.0	65.0
	Хэмжилтийн тоо	-	31	26	16	23	28	31	31	28	27	31	31
Нүүрс- төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	-	-	2.071	3.171	-	1.323	-	1.642	5.251	4.961	2.266
	Хамгийн их	-	-	-	6.538	10.263	-	5.288	-	3.221	14.058	12.361	10.373
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	1.0	-	-	-	-	3.0	4.0	1.0
	Хэмжилтийн тоо	-	-	-	93	71	-	93	-	85	93	93	93
Тоос PM10	Дундаж	0.119	0.205	0.253	0.174	0.408	-	0.213	0.104	0.175	0.331	0.295	0.152
	Хамгийн их	0.320	0.498	0.538	0.493	0.738	-	0.618	0.222	0.296	0.552	0.512	0.327
	XXX*-с давсан хувь	55.0	87.0	90.0	84.0	100.0	-	87.0	42.0	94.0	97.0	97.0	77.0
	Хэмжилтийн тоо	31	31	31	31	26	-	31	31	31	30	31	31
Тоос PM2.5	Дундаж	-	0.156	-	0.127	-	-	-	-	0.164	0.320	0.287	0.134
	Хамгийн их	-	0.360	-	0.373	-	-	-	-	0.285	0.539	0.294	0.298
	XXX*-с давсан хувь	-	97.0	-	93.0	-	-	-	-	97.0	97.0	100.0	94.0
	Хэмжилтийн тоо	-	31	-	27	-	-	-	-	31	30	31	31
Озон O ₃ **	Дундаж	-	-	-	0.013	0.005	-	-	0.032	0.013	0.016	0.015	0.026
	Хамгийн их	-	-	-	0.045	0.029	-	-	0.061	0.610	0.068	0.052	0.069
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	100	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	93	82	-	-	93	79	88	86	82

*- Хүлцэх хэм хэмжээ,

**- CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2017 оны 1-р сарын 4, 5-ны өдрүүдэд хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд нитридийн нэгдлийн хэмжээ хэвийн, хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж онцгой их бохирдолтой, амоны азот 66.2 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 28.0 дахин, эрдэс фосфор 11.5 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч, Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 20. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 1-р сард

	Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O ₂)	≥6	5.78	хэвийн	0.05	горим алдагдаж онцгой их бохир
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ ₅)	≤ 3	1.8		84.0	28.0 дахин
Нитридийн нэгдэл (NO ₂)	≤ 0.02	0.001		0.064	-
Амоны азот (NH ₄)	≤0.5	0.02		33.11	66.2 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	-		1.151	11.5 дахин

*- Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗӨРЧИЛ Нийслэлийн хэмжээнд 2017 оны 1-р сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 4 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 75.0 хувийг газрын зөрчил, 25.0 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчлүүд эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 16.6 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.

Хүснэгт 21. Байгаль орчны зөрчил, төрлөөр, 1-р сард

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2016 он			2017 он		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/
Ой	1	-	-	-	-	-
Ан, амьтан	1	-	-	-	-	-
Газрын	1	4	1.9	2	3	15.9
Ус	-	-	-	-	-	-
Ургамал, хөрсний бохирдол	1	1	0.6	-	-	-
Агаар, химийн хорт бодис	1	3	1.7	1	-	-
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	-	-	-	1	1	0.7
Геодези зураг зүй, кадастр	-	-	-	-	-	-
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	-	-	-	-	-	-
Бусад	2	1	-	1	-	-
Бүгд	7	9	4.2	5	4	16.6



ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ


2017 оны 1 сард нийслэлийн хүн амд 3.2 сая.м3, аж ахуйн нэгж, байгууллагад 0.7 сая.м3 цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан нийт усны хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өссөн байна.

Борлуулсан нийт усны 82.3 хувийг хүн амд, 17.7 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна. Хүн амд түгээсэн цэвэр усны 97.1 хувь буюу 3.1 сая.м3 усыг төвлөрсөн шугамаар, 90.8 мян.м3 усыг ус түгээх байраар, 0.5 мян.м3 усыг тээврээр түгээсэн байна. Цэвэрлэх байгууламжаар 5.0 сая.м3 бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 3.9 сая.м3 бохир шингэнийг татан зайлуулсан байна.


Хүснэгт 22. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013 он I сар	2014 он I сар	2015 он I сар	2016 он I сар	2017 он I сар	2017 2016 %
Шахсан ус	мян.м3	4817.0	4755.2	4472.9	4463.6	4450.2	99.7
Борлуулсан ус	мян.м3	3754.7	3953.0	4027.1	3767.7	3841.2	102.0
Хүн амд	мян.м3	2811.3	2909.7	2964.3	2867.9	3161.9	110.3
ААНБ-д	мян.м3	943.4	1043.3	1062.8	899.8	679.3	75.5
Татан зайлуулсан бохир	мян.м3	3701.3	3838.5	3971.4	3774.9	3870.1	102.5
Хүн амаас	мян.м3	2630.2	2681.5	2789.3	2766.1	3056.6	110.5
ААНБ-аас	мян.м3	1071.1	1157.0	1182.1	1008.8	813.5	80.6
Ус борлуулалтын орлого	сая төг	1318.9	1400.5	2369.0	2186.9	2213.4	101.2
Хүн амаас	сая төг	790.4	815.4	1362.2	1290.1	1430.8	110.9
ААНБ-аас	сая төг	528.5	585.1	1006.8	896.8	782.6	87.3
Сувагжуулалтын орлого	сая төг	731.6	777.0	1452.1	1502.1	1532.6	102.0
Хүн амаас	сая төг	387.3	395.3	620.3	671.0	758.4	113.0
ААНБ-аас	сая төг	344.3	381.7	831.8	831.1	774.2	93.2

Зураг 28. Борлуулсан ус, сараар, мян.м3



Зураг 29. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м3






ГЭМТ ХЭРЭГ

2017 оны 1-р сард 1739 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.2 хувь буюу 4 хэргээр өсчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 61.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.6 пунктээр дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 635 хүн гэмтэж осолдож, 78 хүн нас барж, төр ард иргэдэд 30.2 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 3.5 хувь буюу 1.1 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 30.4 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 29.0 хувийг хулгайн, 10.6 хувийг залилан, 6.8 хувийг танхайн, 4.5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг түс түс эзэлж байна.

Зураг 30. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Хүснэгт 23. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, 1-р сард

Төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2016 он	2017 он	Тоо	Хувь
Хүний амь	10	6	- 4	- 40.0
Хүчин	11	10	- 1	- 9.1
Дээрэм	42	46	4	9.5
Хулгай	585	505	- 80	- 13.7
Булаалт	13	16	3	23.1
Залилан	169	185	16	9.5
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	458	528	70	15.3
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	71	78	7	9.9
Бусдыг амиа хорлоход хүргэх	65	69	4	6.2
Ашиглах	17	13	- 4	- 23.5
Танхайрах	122	118	- 4	- 3.3
Бусад	172	165	- 7	- 4.1
БҮГД	1735	1739	4	0.2

2017 оны 1-р сард 3233 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 29.5 хувь буюу 1356 хүнээр буурсан байна.

Хүснэгт 24. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, 1-р сард

Дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2016 он	2017 он	Тоо	Хувь
Багануур	34	17	- 17	- 50.0
Багахангай	4	1	- 3	- 75.0
Баянгол	292	328	36	12.3
Баянзүрх	391	411	20	5.1
Налайх	40	32	- 8	- 20.0
Сонгинохайрхан	299	252	- 47	- 15.7
Сүхбаатар	295	274	- 21	- 7.1
Чингэлтэй	214	268	54	25.2
Хан-Уул	166	156	- 10	- 6.0
ДҮН	1735	1739	4	0.2

Хүснэгт 25. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 1-р сард


Дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	6	4	66.7
Багахангай	1	-	0.0
Баянгол	142	94	66.2
Баянзүрх	260	121	46.5
Налайх	12	9	75.0
Сонгинохайрхан	162	76	46.9
Сүхбаатар	191	94	49.2
Чингэлтэй	182	73	40.1
Хан-Уул	85	45	52.9
ДҮН	1041	516	49.6

Хүснэгт 26. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, 1-р сард

Дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2016 он	2017 он	2016 он	2017 он
Багануур	4	5	4	3
Багахангай	1	1	-	1
Баянгол	70	63	56	44
Баянзүрх	126	122	106	105
Налайх	6	12	4	10
Сонгинохайрхан	126	69	119	64
Сүхбаатар	120	86	101	78
Чингэлтэй	87	98	76	87
Хан-Уул	45	49	41	44
ДҮН	585	505	507	436

2017 оны 1-р сард хүндэвтэр хэрэг 738, онц хүнд хэрэг 25 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7.5-34.2 хувиар буурч, харин хүнд хэрэг 92, хөнгөн хэрэг 884 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3.3-9.1 хувиар өсчээ.

Зураг 31. Гэмт хэргийн тоо, ангиллаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 1134 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.2 хувь буюу 66 хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 22.4 хувь буюу 254 нь согтуугаар үйлдсэн, 14.5 хувь буюу 164 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 6.3 хувь буюу 72 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 4.8 хувь буюу 54 нь хүүхэд, 16.5 хувь буюу 187 нь эмэгтэйчүүд байна.



ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2017 оны 1-р сард 16 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 64.5 хувиар буурсан байна. Нийт гамшигт хүчтэй шороон шуурга 1, мал амьтны халдварт галзуу өвчин 1, хүний үйл ажиллагаатай холбоотой 14 осол бүртгэгдсэн байна. Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд химийн бодисын 1 осол, бусад төрлийн 14 осол бүртгэгджээ. Гамшгийн улмаас 1 хүн амь насаа алдаж, 7 хүнийг аварч, гамшгийн үршгийг арилгах ажилд нийт 0.9 сая төгрөг зарцуулжээ.


Хүснэгт 27. Гал түймрийн тоо, дүүргээр

Дүүрэг	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2017 он
							2016 он
Бүгд	264	285	393	320	259	216	83.4
Багануур	1	1	4	3	2	3	150.0
Багахангай	0	0	1	2	1	0	0
Баянгол	49	43	71	39	36	43	119.4
Баянзүрх	59	64	93	80	64	38	59.4
Налайх	13	4	16	9	10	10	100.0
Сонгинохайрхан	40	66	76	66	57	52	91.2
Сүхбаатар	45	32	46	37	34	22	64.7
Хан-Уул	18	27	49	35	25	23	92.0
Чингэлтэй	39	48	37	49	30	25	83.3


Нийслэл хотод 2017 оны 1-р сард ахуйн 216 гал түймэр гарсан байна. Ахуйн гал түймэр өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар буурсан байна. Гал түймрийн улмаас 3 хүн (үүнээс, хүүхэд 3) амь насаа алдаж, гал түймрийн улмаас түлэгдэж гэмтсэн хүн байхгүй. Гал түймрийн аюулаас 34 хүн, 73 байшин барилга, 173.7 сая төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 27, санамсаргүй байдлаас 184, бусад шалтгаанаар 5 гал түймэр гарчээ.

Гал түймэрт 107 гэр, орон сууц, 19 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 9 машин техник, малын 21 хашаа, саравч, бусад төрлийн 60 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 131, төрийн өмчийн 64, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 21 объект өртөж, нийт 370.5 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 32. Гал түймэр, шалтгаанаар



Зураг 33. Гал түймэр, байршлаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2017 оны 1-р сард 16 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 5 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 1266 айл өрх, 751 объектод үзлэг шалгалт хийж, 4096 галын зөрчил илрүүлж, 13 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 256 заавал биелүүлэх албан шаардлага, 238 мэдэгдэл хүргүүлж, 6.7 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР